



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2023/03/НА-СТА-ОНӨ

Цахим хуудас:
www.audit.mn
Эрдэнэт хот
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70359826 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70357955 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn
Аудитор: Г.Даваасүрэн
Утас: 70350757 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2023.03.15 № 97

танай _____-ны № _____-г

ЭРДЭНЭТ ШИНЖЛЭХ УХААН
ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨААТҮГ -ЫН ГҮЙЦЭТГЭГЧ
ЗАХИРАЛ Г.ЭНХБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ -ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ -ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 32 дугаар хуралдааны шийдвэрээр 2022 оны бизнес төлөвлөгөөнд орлого 582,800.0 мянган төгрөг, зардал 579,430.0 мянган төгрөгөөр баталснаас мөнгөн гүйлгээний тайлангаар орлого 823,700.2 мянган төгрөг, зардал 806,052.4 мянган төгрөг зарцуулсан байна. Дээрх онцгойлсон асуудалтай холбоотой аудиторын дүгнэлт өөрчлөгдөөгүй болно.

Аудитын гол асуудал

Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ нь тайлант хугацаанд Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар "Гарааны бизнес-2022" төсөл санхүүжилт 270,000.0 мянган төгрөг, "Цахим эрдэнэт-1" хөтөлбөр 132,000.0 мянган төгрөг, "Олон улсын төсөл хөтөлбөр, төлөөлөгчийн байгууллагуудтай хамтран ажиллах" хөтөлбөр 64,900.0 мянган төгрөг нийт 466,900.0 мянган төгрөгийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн нь байгууллагын орлого, зардлын дүнг өсгөсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдээс зүй бусаар нөлөөлөх нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>876,136,163.22</u>	<u>923,295,126.54</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	270,236,103.22	205,548,887.69
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	270,236,103.22	205,548,887.69
31213	Арилжааны банк дахь харилцах	270,236,103.22	205,548,887.69
33	АВЛАГА	576,500,364.85	679,612,729.92
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	35,364.85	9,639,729.92
336	Зээлийн авлага	506,070,000.00	669,973,000.00
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	506,070,000.00	669,973,000.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл	506,070,000.00	669,973,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	29,399,695.15	38,133,508.93
351	Түүхий эд материал	14,470,372.73	19,263,331.82
35110	Тусгай зориулалттай материал	14,470,372.73	19,263,331.82
354	Хангамжийн материал	13,447,322.42	18,870,177.11
35470	Бусад хангамжийн материал	13,447,322.42	18,870,177.11
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>847,947,211.13</u>	<u>2,816,821,716.51</u>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	100,000,000.00	100,000,000.00
371	Урт хугацаат хадгаламж	100,000,000.00	100,000,000.00
37110	Төгрөг	100,000,000.00	100,000,000.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	747,947,211.13	2,716,821,716.51
392	Биет хөрөнгө	746,507,211.13	2,465,561,716.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	447,794,300.00	1,483,098,090.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-22,389,715.08	-58,988,284.83
39203	Авто-тээврийн хэрэгсэл	35,000,000.00	35,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-11,958,333.10	-15,458,333.01
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	356,130,784.30	448,754,829.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	-112,767,577.10	-154,446,956.44
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	59,002,855.00	66,021,036.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,393,911.35	-27,460,190.99
39214	Бусад үндсэн хөрөнгө	58,209,718.19	198,507,740.01
39215	Хуримтлагдсан элэгдэл	-42,120,909.73	-60,066,214.80
39216	Дуусаагүй барилга, байгууламж		550,600,000.00
393	Биет бус хөрөнгө	1,440,000.00	251,260,000.00
39301	Програм хангамж	3,800,000.00	3,800,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,360,000.00	-2,540,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө		250,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,724,083,374.35</u>	<u>3,740,116,843.05</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>540,583,255.68</u>	<u>637,000,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	540,583,255.68	637,000,000.00
413	Өглөг	540,583,255.68	637,000,000.00
4136	Бусад өглөг	540,583,255.68	637,000,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	540,000,000.00	637,000,000.00

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,183,500,118.67	3,103,116,843.05
51	Засгийн газрын хувь оролцоо	1,183,500,118.67	3,103,116,843.05
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,184,058,063.75	3,230,795,673.75
51101	Өмч: - төрийн	1,150,103,063.75	1,150,103,063.75
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	33,955,000.00	2,080,692,610.00
512	Хуримтлагдсан үр дүн	-557,945.08	-127,678,830.70
51220	Тайлант үеийн үр дүн	-557,945.08	-127,678,830.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,724,083,374.35	3,740,116,843.05

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	126,918,228.81	441,105,798.33
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	126,918,228.81	441,105,798.33
120	Нийтлэг татварын бус орлого	126,918,228.81	441,105,798.33
120001	Хувьцааны ногдол ашиг	12,500,000.00	20,674,374.00
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	164,702,818.17	432,279,011.60
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	-50,284,589.36	-11,847,587.27
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	229,336,102.62	568,226,683.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	229,336,102.62	568,226,683.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	229,336,102.62	568,226,683.95
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	229,336,102.62	568,226,683.95
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/	9,998,496.21	53,082,700.72
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	183,668,151.86	438,191,988.23
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/	1,800,000.00	350,000.00
210813	Бусад зардал /ТӨҮГ/	33,869,454.55	76,601,995.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-102,417,873.81	-127,120,885.62
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-102,417,873.81	-127,120,885.62

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,184,058,063.75	-557,945.08	1,183,500,118.67
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,184,058,063.75	-557,945.08	1,183,500,118.67
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт			0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			0.00

C07	Тайлант үеийн үр дүн			0.00
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,184,058,063.75		1,183,500,118.67
D01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,150,103,063.75	101,859,928.74	1,183,500,118.67
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,184,058,063.75		1,183,500,118.67
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт			0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт			
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	2,046,737,610.00		2,046,737,610.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			0.00
D08	Тайлант үеийн үр дүн		-127,120,885.62	-127,120,885.62
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,230,795,673.75	-127,678,830.70	3,103,116,843.05

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>683,207,363.62</u>	<u>823,700,234.12</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	683,207,363.62	823,700,234.12
120	Нийтлэг татварын бус орлого	683,207,363.62	823,700,234.12
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	683,207,363.62	823,700,234.12
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>241,937,114.61</u>	<u>806,052,394.56</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	241,937,114.61	806,052,394.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	241,937,114.61	806,052,394.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	62,160,856.51	117,358,989.33
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	62,160,856.51	117,358,989.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,082,225.23	33,674,054.80
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	19,082,225.23	33,674,054.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,401,061.84	21,496,253.23
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	10,401,061.84	21,496,253.23
2104	Хангамж, бараа материалын зардал	47,895,297.39	68,652,112.68
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	4,590,173.73	9,459,649.25
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	43,305,123.66	59,192,463.43
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	102,397,673.64	564,870,984.52
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	29,255,482.57	20,045,512.59
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	73,142,191.07	544,825,471.93
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>441,270,249.01</u>	<u>17,647,839.56</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	12,500,000.00	20,674,374.00
140008	Хүлээн авсан ногдол ашиг	12,500,000.00	20,674,374.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	27,869,936.36	29,106,429.09
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27,869,936.36	29,106,429.09
2200	Дотоод эх үүсвэрээр	27,869,936.36	29,106,429.09
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	27,869,936.36	29,106,429.09

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-15,369,936.36	-8,432,055.09
14	Бусад эх үүсвэр	80,221,000.00	155,097,000.00
145007	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	80,221,000.00	155,097,000.00
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	245,000,000.00	229,000,000.00
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	245,000,000.00	229,000,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-164,779,000.00	-73,903,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	261,121,312.65	-64,687,215.53
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,114,790.57	270,236,103.22
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	270,236,103.22	205,548,887.69

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Биелэлт	Биелэлт ийн хувь	Тайлбар
Санхүүгийн орлого					
5.1.	Захиргааны менежментийн үйл ажиллагааны орлого	120,000,000.00	126,286,600.00	105%	
5.2.	"Цахим Эрдэнэт-1" хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны орлого	150,000,000.00	132,000,000.00	88%	Орон нутгийн төсөвт батлагдсан дүнгээр орлого буурсан
5.3.	"Эрдэнэтэд үйлдвэрлэв" хөтөлбөр хэрэгжүүлэх орлого	92,800,000.00	92,800,000.00	100%	
5.4.	Хамтарсан үйлдвэрийн 49 хувьд ноогдох татварын дараах цэвэр ашиг	20,000,000.00	20,094,174.00	100%	
5.5.	Бизнес инкубатор төвийн орлого	100,000,000.00	0.00	0%	Будгийн үйлдвэр, Гагнуурын электродны үйлдвэр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт татаж орлого төвлөрүүлэхээр төлөвлөсөн боловч шийдвэр гараагүй
5.6.	Бизнес хөгжлийн төвийн орлого	30,000,000.00	11,047,903.00	37%	Байгууллагуудад чиглэгдсэн сургалтууд бэлтгэгдээгүй
5.7.	Технологи дамжуулах төвийн орлого	70,000,000.00	22,900,000.00	33%	ШУТС-гаас санхүүжилт он дамнасан, "Цахим Эрдэнэт - 1" хөтөлбөрийн хүрээнд аян зохион байгуулахад технологи, инновацийн ажлууд давхар төлөвлөгдөж хойшилсон
Санхүүгийн зардал					
5.8.	Ажилтнуудын цалин	150,000,000.00	143,273,098.00	96%	Төлөвлөгөө биелсэн
5.9.	Аж ахуй нэгжээс төлөх НДШ	18,750,000.00	17,619,642.00	94%	Төлөвлөгөө биелсэн
5.10.	Хоолны хөнгөлөлт	6,000,000.00	5,940,494.00	99%	Төлөвлөгөө биелсэн

5.11.	Бичиг хэргийн материал, хаягжуулалт	7,000,000.00	4,646,175.00	66%	Төрийн хэмнэлтийн тухай хууль болон өөрийн орлого буурснаар хэмнэж ажилласан
5.12.	Шуудан холбоо	7,000,000.00	7,008,731.00	100%	Төлөвлөгөө биелсэн
5.13.	Ус, дулаан, цахилгааны зардал	27,000,000.00	22,132,886.00	82%	Төлөвлөгөө биелсэн
5.14.	Түрээсийн зардал	10,800,000.00	9,830,120.00	91%	Баян төвд ажиллаж байсан дэлгүүрийг нэг сарын өмнө шилжүүлсэн
5.15.	Засвар, үйлчилгээний зардал	5,000,000.00	6,851,100.00	137%	Судалгааны ажилтай холбоотойгоор таримал мөөгний судалгааны орчин үүсгэхэд нэмэлт зардал гарсан
5.16.	Цэвэрлэгээ, ариутгалын материалын зардал	1,100,000.00	2,104,998.00	191%	Судалгааны ажилтай холбоотойгоор таримал мөөгний судалгааны орчин үүсгэхэд нэмэлт зардал гарсан
5.17.	Шатахуун, тээврийн зардал	9,000,000.00	8,180,064.00	91%	Төрийн хэмнэлтийн тухай хууль болон өөрийн орлого буурснаар хэмнэж ажилласан
5.18.	Хангамж, түүхий эд материалын зардал	53,000,000.00	40,588,373.00	77%	Төлөвлөгөө биелсэн
5.19.	Гадна хаяг, хэвлэл, зар сурталчилгаа	3,000,000.00	1,449,000.00	48%	Төрийн хэмнэлтийн тухай хууль болон өөрийн орлого буурснаар хэмнэж ажилласан
5.20.	Элэгдлийн зардал	50,000,000.00	111,472,000.00	223%	Хөрөнгө нэмэгдсэн
5.21.	Банкны үйлчилгээний шимтгэлийн зардал	150,000.00	281,645.00	188%	Гүйлгээний тоо төлөвлөлтөөс давсан
5.22.	Гадаад, дотоод томилолт	50,000,000.00	101,472,000.00	203%	Аймгийн ЗДТГ-ын мэргэжилтнүүдийн судалгааны зардал нэмэгдсэн
5.23.	Ажилтнуудыг чадавхжуулах сургалт	21,000,000.00	6,359,400.00	30%	Төрийн хэмнэлтийн тухай хууль болон өөрийн орлого буурснаар хэмнэж ажилласан
5.24.	Бусдаар гүйцэтгүүлэх ажил	20,000,000.00	24,935,300.00	125%	Судалгааны ажилтай холбоотойгоор таримал мөөгний судалгааны орчин үүсгэхэд нэмэлт зардал гарсан
5.25.	Цахим Эрдэнэт-1 хөтөлбөрийн мэдээлэл, сурталчилгаа	35,000,000.00	30,000,000.00	86%	Төлөвлөгөө биелсэн
5.26.	Бизнес хөгжлийн төвийн гадна засвар /шат, усны хаялга/	10,000,000.00	9,768,000.00	98%	Төлөвлөгөө биелсэн
5.27.	Бизнес төвийн камержуулалт, тохижилт	6,500,000.00	4,547,020.00	70%	Төрийн хэмнэлтийн тухай хууль болон өөрийн орлого буурснаар хэмнэж ажилласан

5.28.	Бизнес инкубатор төвийн тохижилт	24,000,000.00	4,990,000.00	21%	Төрийн хэмнэлтийн тухай хууль болон өөрийн орлого буурснаар хэмнэж ажилласан
5.29.	Тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтын зардал	30,000,000.00	23,165,350.00	77%	
5.30.	Технологи дамжуулах төвийн тохижилт /хаалга, тавилга/	5,500,000.00	7,660,000.00	139%	Оффисийн өрөө, тасалгаа үүсгэхэд материалын үнэ, ажлын хөлс нэмэгдсэн
5.31.	ААНОАТ -зардал	3,725,000.00	0.00	0%	Татвар ноогдоогүй
5.32.	НӨАТ-ын зардал	3,210,000.00	0.00	0%	НӨАТ-ийн өглөг үүсээгүй
5.33.	Газрын төлбөр	2,000,000.00	2,000,000.00	100%	Төлөвлөгөө биелсэн
5.34.	Авто машин, өөрөө явагч хэрэгслийн зардал	100,000.00	84,395.00	84%	Төлөвлөгөө биелсэн
5.35.	Авто машины агаарын бохирдлын зардал	10,000.00	9,500.00	95%	Төлөвлөгөө биелсэн
5.36.	Санхүүгийн програмын лиценз	385,000.00	385,000.00	100%	Төлөвлөгөө биелсэн
5.37.	Санхүүгийн аудитын төлбөр	1,800,000.00	1,800,000.00	100%	Төлөвлөгөө биелсэн
5.38.	Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх	3,000,000.00	0.00	0%	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд хэмнэсэн
5.39.	Байгаль орчин төлөв байдлын үнэлгээний төлбөр	7,500,000.00	4,500,000.00	60%	Ажил он дамнасан
5.40.	Ахмадын сан	200,000.00	200,000.00	100%	Төлөвлөгөө биелсэн
5.41.	Байгаль орчныг хамгаалах	1,000,000.00	210,000.00	21%	Өөрийн орлого буурсанаас хэмнэсэн
5.42.	ШУ-ны олон улсын байгууллагад гишүүнчлэлийн төлбөр	4,500,000.00	4,465,890.00	99%	Төлөвлөгөө биелсэн
5.43.	Бусад зардал	1,000,000.00	1,780,310.00	178%	Гурван ажилтан ХЧТА-ны тэтгэмж үүссэн, санхүү хяналт аудит төлбөрийн акт төлсөн
5.44.	ШУ, инновацийн арга хэмжээ зохион байгуулах зардал	21,000,000.00	23,311,200.00	111%	Дархан-Уул аймагт нэмэлтээр үзэсгэлэн, сургалтын ажилд оролцсон.

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 50,944.3 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 6,490.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 30,000.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 14,454.3 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Гадаад томилолтын зардалд 6,490,000 төгрөг илүү шилжүүлэн олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:", 4.1.1-д "энгийн хялбар, чанга хатуу байх;", 4.1.2-д "хүлээн зөвшөөрөгдөхүйц байх;", 4.1.3-д "үр ашигтай байх;", 4.2.7-д "аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх;", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам" -ын 2 дугаар зүйлийн 2.1-д "Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно." гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

5.2 Албан шаардлага

1. Үйлдвэрийн газрын төлбөр тооцоог мөнгөн кассаар дамжуулан бэлэн мөнгөөр хяналтгүйгээр зарцуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Захирал дараах эрх, үүрэгтэй:" 7/ -д "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах;", "Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк" ОНӨААТҮГ-ийн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.4-д "Паркийн үйл ажиллагааны талаар хууль тогтоомжийн хүрээнд тушаал гаргах, санхүүгийн баримтад нэгдүгээр гарын үсэг зурах" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

2. Үйлдвэрийн газрын 2022 оны бизнес төлөвлөгөөнд тусгаагүй "Нөөц халаалтын системийн зуух" худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 41 дүгээр зүйлийн 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.7-д "аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх;" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: 1.

Харилцах данснаас зарлагын гүйлгээг зөвхөн нягтлан бодогчийн эрхтэй цахим гүйлгээгээр хийсэн байна.

Өгсөн зөвлөмж: Харилцах данснаас зарлагын гүйлгээг хийхдээ үйлдвэрийн газрын даргын гарын үсэгтэй гүйлгээг хийж байх

2. Санхүү бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: 2.

Худалдаж авсан хүнсний материалыг бараа материалын дансанд бүртгээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үйлдвэрийн газрын хэрэгцээ шаардлагаар худалдаж авсан бараа материалыг бүртгэл тайланд бүртгэж хэвших.

Илрүүлэлт: 3.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулах 485,615.5 мянган төгрөгийн 35 мэдээллийг огт мэдээлэлгүй орхигдуулсан байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөвөөр бүрэн мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ	5	50,944.3	1	1,490.0	2	30,000.0	2	19,454.3				
Дүн	5	50,944.3	1	1,490.0	2	30,000.0	2	19,454.3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ	1	-					1	-
Дүн	1	-					1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	-					1	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

